



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/281

Номгон

Нисэхийн хамгаалалтын бүсийг шинэчлэн
тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь заалт, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2, 20.2.7, Зам тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 07 сарын 16-ны өдрийн “Аэродромын төлөвлөлт ба ашиглалт А/131 дугаар тушаалын 7.5.3.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1.Баянхонгор сумын нутагт орших Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа “Баянхонгор” нисэх буудлын аэродромын орчмын аюулгүйн бүсийн эргэлтийн солбицлыг нэгдүгээр хавсралтаар, аэродром орчмын аюулгүйн бүсийн зураглалыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2.Аэродромын орчмын аюулгүйн бүсэд газар эзэмшиж ашиглаж байгаа иргэн, аж ахуй нэгжтэй байгуулсан гэрээг шинэчлэн аюулгүйн бүсэд мөрдөх хууль журмыг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор сумын Засаг дарга (Ж.Мөнхсоёл), Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар (Д. Алтангэрэл) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Аэродромын орчмын аюулгүйн бүсэд иргэн, аж ахуй нэгжийн явуулж буй үйл ажиллагаа нисэхийн аюулгүй байдалд нөлөөлж байгаа эсэхэд хяналт тавьж хамтын уялдаа холбоог хангаж ажиллахыг Баянхонгор сумын засаг дарга (Ж.Мөнхсоёл), Нисэх буудлын дарга (Ж. Ганхүлэг) нарт үүрэг болгосугай.

4.Аэродромын тусгай бүсийн дэглэмтэй холбоотой мэдээллээр иргэд, олон нийтийг хангаж ажиллахыг Нисэх буудлын дарга (Ж. Ганхүлэг)-д үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөө аж ахуй, дэд бүтэц хариуцсан орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

6.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн “Нисэхийн хамгаалалтын бүс тогтоох тухай” А/567 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

521010713

Аймгийн Засаг даргын 2009 оньр 04 дүгээр сарын
29-ний өдрийн /291/ дүгээр захирамжийн
1 дүгээр хэсэг



НИСЭХ БУУДЛЫН АЭРОДРОМЫН ОРЧМЫН АЮУЛГҮЙН
БҮСИЙН ЭРГЭЛТИЙН СОЛБИЦОЛ



1. Тусгай бүс		
X=635237.2961	Y=5108109.1930	Z=5660.6017
X=633428.2896	Y=5107256.2596	Z=5660.6017
X=628264.0896	Y=5118209.1323	Z=5660.6017
X=630073.0961	Y=5119062.0657	Z=5660.6017
2. Агаарын хөлгийн ойртолтын бүс		
X=635237.2961	Y=5108109.1930	Z=5660.6017
X=641401.8833	Y=5098914.7817	Z=5660.6017
X=636599.3713	Y=5096650.4321	Z=5660.6017
X=633428.2896	Y=5107256.2596	Z=5660.6017
X=635237.2961	Y=5108109.1930	Z=5660.6017
X=641401.8833	Y=5098914.7817	Z=5660.6017
X=636599.3713	Y=5096650.4321	Z=5660.6017
X=633428.2896	Y=5107256.2596	Z=5660.6017
3. "А" бүс		
X=629008.9130	Y=5109594.8724	Z=5660.6017
X=627256.4472	Y=5113311.7182	Z=5660.6017
X=634492.4732	Y=5116723.4519	Z=5660.6017
X=636244.9390	Y=5113006.6062	Z=5660.6017
X=629008.9130	Y=5109594.8724	Z=5660.6017
4. "Б" бүс		
Center point, X=631750.6931	Y=5113159.1622	Z=5660.6017
Radius 15000.0000		

_____оОо_____

Аймгийн засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн

281 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралт

АЭРОДРОМ ОРЧМЫН АЮУЛГҮЙН БҮСИЙН ЗУРАГЛАЛ



ТАЙЛБАР:

- 1 - Тусгай бүс
- 2 - Агаарын хөлгийн ойртолтын бүс
- 3 - "А" бүс
- 4 - "Б" бүс

1. АЭРОДРОМЫН ТУСГАЙ БҮС

-Нисэх зурвасын тэнхлэгээс 2 хажуу тийш 1км зурвасын эхлэл болон төгсгөлөөс 4км хүртэл хамрах талбай. Энэ бүсэд нисэх буудлын аэродром болон аэронавигацийн барилга байгууламжаас бусад барилга байгууламж, объект барихыг хориглоно.

-Гэхдээ одоо байгаа барилга байгууламж болон гэр хорооллыг хэвээр үлдээж, шинээр барилга байгууламж, объект барихыг хориглоно.

2. АГААРЫН ХӨЛГИЙН ОЙРТОЛТЫН БҮС

-15м хүртэл өндрийн хязгаарлалттай барилга байгууламжтай.

-Гэрэлт дохион тэмдэглэгээтэй.

-Нисэхийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхгүй болон жигүүртэн ан амьтан үл цуглуулах нөхцөлтэй барилга байгууламжийг төлөвлөх бөгөөд Иргэний Нисэхийн Ерөнхий газраас зөвшөөрөл авч хянуулах.

3. "А" БҮС

- 30м хүртэлх өндрийн хязгаарлалттай барилга байгууламжтай.

- Гэрэлт дохион тэмдэглэгээтэй.

- Аэродромын аюулгүйн бүсэд одоо эзэмшиж байгаа барилга байгууламж, түүний газар ашиглалт нь нисэхийн аюулгүй үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхгүй болон жигүүртэн ан амьтан үл цуглуулах нөхцөлтэй барилга байгууламж байна. Мөн 25-30м өндөр төлөвлөлт хийх үед Иргэний Нисэхийн Ерөнхий газрын харьяа Баянхонгор нисэхтэй зөвшилцөн төлөвлөнө.

4. "Б" БҮС

-Шинээр төлөвлөж буй барилга байгууламж, объект нь нислэгийн ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх ба жигүүртэн ан амьтан үл цуглуулах нөхцөлтэй барилга байгууламж төлөвлөх.

-Нисэх буудлын орчмын нутаг дэвсгэр дэх аэродромын тусгай болон аэродромын бүсүүдэд нисэхийн аюулгүй байдалд шууд болон шууд бусаар нөлөөлөх, шувууд цугларах нөхцөлийг бүрлүүлэхүйц барилга байгууламж, объект /мал нядалгааны газар, мал аж ахуй эрхлэх, хогийн цэг г.м/ барьж байгуулахыг хатуу хориглоно.

АЭРОДРОМЫН АЮУЛГҮЙ БҮСИЙН ЗУРАГ, ТАЙЛБАР ГҮЙЦЭТГЭСЭН:

АЙМГИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР

НИСЭХ БУУДЛЫН АЭРОДРОМЫН ТЕХНИКЧ

С.ХҮРЭЛХУЯГ

Г.БАЯНЖАРГАЛ